



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/325

Есөнбулаг сум

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зориулалтаар 2026 онд агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Чинзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Цэрэнбал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Д.Батмагнай (Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Содмаа (Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Олонбаатар (Байгаль орчны газрын биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн)

2.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ